



МОНГОЛ УЛС ШАДАР САЙДЫН ТУШААЛ

2020 оны 11 дугаар
сарын 30 -ны өдөр

Дугаар 149

Улаанбаатар
хот

Түр журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.5, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 194 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гамшигаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед боловсруулах үйлдвэрийн салбарын халдварт хамгааллын дэглэмийг мөрдүүлэх зорилго бүхий “Боловсруулах үйлдвэрийн салбарын хуулийн этгээдийн үйл ажиллагаанд халдварт хамгааллын дэглэм мөрдөх түр журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү түр журмын хэрэгжилтийг ханганд, коронавируст халдварт цар тахлын тархалт, халдварт хамгааллын нөхцөл, орон нутгийн онцлог зэргийг харгалзан тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид энэхүү түр журам болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн зохих шийдвэр гаргаж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Аймаг, нийслэлийн Онцгой комиссын дарга наарт үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Онцгой комиссын орлогч дарга, Онцгой байдлын ерөнхий газрын дарга (бригадын генерал Г.Ариунбуян)-д даалгасугай.

Монгол Улсын Шадар сайд



Я. СОДБААТАР

Я. СОДБААТАР

2010604

БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАЛДВАР ХАМГААЛЛЫН
ДЭГЛЭМ МӨРДӨХ ТҮР ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү түр журмын зорилго нь Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед Боловсруулах үйлдвэрийн салбарын хуулийн этгээдийн үйл ажиллагаанд халдварт хамгааллын дэглэмийг мөрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед Боловсруулах үйлдвэрийн салбарын хуулийн этгээдийн үйл ажиллагаанд Гамшгаас хамгаалах тухай, Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай, Эрүүл мэндийн тухай, Эрүүл ахуйн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 194 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/269 дүгээр тушаалаар баталсан “Коронавируст халдвартын үед халдвартгүйжүүлэлт хийх түр заавар” болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг мөрдлөг болгоно.

1.3. Түр журам нь Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлчлэх бөгөөд холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөнө.

1.4. Энэхүү түр журмаар зохицуулаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, дүрэм, журмаар зохицуулна.

**Хоёр. Боловсруулах үйлдвэрийн салбарын хуулийн этгээдэд
тавигдах нийтлэг шаардлага, хүлээх үүрэг**

2.1. Боловсруулах үйлдвэрийн салбарын хуулийн этгээдэд дараах нийтлэг шаардлага тавигдана.

2.1.1. Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар тогтоосон хугацааны хязгаарлалтад нийцүүлэн байгууллагын үйл ажиллагааны цагийн хуваарь баталж, мөрдүүлэх;

2.1.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, халдварт хамгааллын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангах;

2.1.3. Түр тусгаарлах өрөөг бэлтгэх, анхны тусламж үзүүлэх хайрцааг, хувийн хамгаалах хувцас хэрэгслийн нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах;

2.1.4. Баталгаат ундны усны эх үүсвэрээр хангагдсан байх;

2.1.5. Ажилчдыг байгууллагын унаагаар, эсхүл нийтийн тээврийн хэрэгслээр тээвэрлэх, зөвшөөрөгдсөн тохиолдолд хувийн тээврийн хэрэгслээр зорчих нөхцөл, боломжийг бүрдүүлэх;

2.1.6. Ажилчид, мөн үйлчлүүлэгсэд хооронд 1-1.5 метр зйтай байх нөхцөлийг бүрдүүлэх, шаардлагатай тохиолдолд зайд барих тэмдэг тэмдэглэгээжүүлэх;

2.1.7. Ажилчдын халдварт хамгааллын дэглэмийг мөрдүүлж, гар угаах, ариун цэвэр сахих нөхцөлийг бүрдүүлэх.

2.2. Боловсруулах үйлдвэрийн салбарын хуулийн этгээд дараах үүрэг хүлээнэ.

2.2.1. Ажилчдын бүртгэл, тээврийн хэрэгслийн жагсаалтыг харьяа сум, дүүргийн Онцгой комисст цахимаар хүргүүлэх;

2.2.2. Эрүүл мэндийн сайдын 2020 оны А-269 дүгээр тушаалаар баталсан “Коронавируст халдвартын үед халдвартгүйжүүлэлт хийх түр заавар”-ыг үйл ажиллагаандаа чанд сахиж мөрдөх;

2.2.3. Коронавируст халдвартын цар тахлаас урьдчилан сэргийлэх санамж, зөвлөмжийг ажлын байранд харагдахуйц байршуулах;

2.2.4. Ажлын байр, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг өдөрт 2-оос доошгүй удаа буюу ажил эхлэхийн өмнө болон дараа чийгтэй цэвэрлэгээ хийж халдвартгүйжүүлэх, бодисын уусмалаар дээрээс доош, гаднаас дотогш, цэврээс бохир чиглэлд арчих эсхүл шүрших;

2.2.5. Ажлын байранд салхивчийг 2 цаг тутамд 10-15 минутын хугацаатай онгойлгож агаар сэлгэлт хийх;

2.2.6. Дотоод хяналтын нэгж, ажилтны хариуцлагыг өндөржүүлж, халдвараас сэргийлэх хяналтыг тогтмол тавьж бүртгэл хөтлөх;

2.2.7. Ажлын байранд нэвтрэх ажилчдын биеийн халууныг хэмжиж тэмдэглэл хөтлөх, халдвартын сэжигтэй шинж тэмдэг /37.1 хэмээс дээш халуурах, ханиалгах, амьсгаадах/ илэрсэн үед эрүүл мэндийн байгууллагад нэн даруй мэдээлж, түр тусгаарлах;

2.2.8. Ажилчдын ирцийг өдөр бүр бүртгэх, ирээгүй ажилчдын шалтгааныг тодруулж хяналт тавих;

2.2.9. Хог хаягдлыг төрөлжүүлэн зориулалтын саванд цуглуулж тухай бүр зайлзуулах, байгууллагын гадна орчны 50 метр хүртэлх газрыг цэвэрлэх;

2.2.10. Мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу ажилчдыг ажлын байранд хувийн хамгаалах хэрэгсэл /ам, нүүрний хаалт, нэг удаагийн бээлий, гар халдвартгуйжүүлэх бодис/-ээр хангах;

2.2.11. Ажлын байранд спиртийн агууламж бүхий гар халдвартгуйжүүлэх бодисыг хүрэлцээтэй байршуулах;

2.2.12. Ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур, шатны болон хаалганы бариул, цахилгаан шатны товчлуур, гэрлийн унтраалга, сандал, ширээ, шүүгээ, сейф, сагс, тэрэгний бариул, төлбөрийн болон хөнгөлөлтийн карт уншигч машин, мөнгөний ATM машины товчлуур зэрэг хамгийн их хүрэлцдэг гадаргууг 2 цаг тутамд, мөн бохирлогдсон тухай бүрт цэвэрлэж халдвартгуйжүүлэх;

2.2.13. Шаардлагатай тохиолдолд Кovid-19 халварын шинжилгээнд ажилчдыг хамруулах арга хэмжээг Эрүүл мэндийн байгууллагатай хамтран зохион байгуулах;

2.2.14. Ажилчдад дархлааг дэмжих эм бэлдмэл, шим тэжээлээр баялаг хоол, хүнсээр үйлчлэх;

2.2.15. Ажилчдыг шаардлагатай тохиолдолд ээлжээр, сэлгэн ажиллуулах;

2.2.16. Ажлын байрын дарамт, стресс үүсгэхгүй байх.

2.3. Албаны журмаар зайлшгүй нэвтрэх шаардлагатай албан хаагчдыг бүртгэж, халууныг хэмжин, гарыг халдвартгуйжүүлж, зохих журмын дагуу нэвтрүүлнэ.

2.4. Мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу ажилчдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийг ажлын байранд угаах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.5. Боловсруулах үйлдвэрийн салбарын хуулийн этгээдэд дараах зүйлийг хориглоно:

2.5.1. Халдвартгуйжүүлэх хамгааллын дэглэм сахиагүй ажилчдыг ажиллуулах;

2.5.2. Байгууллагын хурал, семинар, олон нийтийн ажил зохион байгуулах;

2.5.3. Батлагдсан болон сэжигтэй, тусгаарлан ажиглах байранд болон гэрийн тусгаарлалтад байгаа ажилчдыг ажлаас халах;

2.5.4. Ажлын байранд иргэдийг гаднаас зөвшөөрөлгүй нэвтрүүлэх.

Гурав. Ажилтны хүлээх үүрэг

3.1. Боловсруулах үйлдвэрийн салбарын хуулийн этгээдийн ажилтан дараах үүрэг хүлээнэ:

3.1.1. Ажлын байранд нэвтрэхдээ биеийн халууныг хэмжүүлэх, эрүүл мэндийн тандалт, асуумж /толгой өвдөх, хоолой хөндүүрлэх, ханиах, найтаах, хамраас нус гоожих, үе мөч, цээжээр өвдөх, амьсгал давчдах, мөн халдвартай нь батлагдсан болон сэжигтэй тохиолдлын ойрын хавьтал г.м/-ийг үнэн зөв мэдүүлэх;

3.1.2. Амны болон нүүрний хаалт байнга зүүж хэвших;

3.1.3. Хоол идэхийн өмнө, бие зассаны дараа, бохирдсон тухай бүрт гарыг угааж халдвартгүйжүүлэх;

3.1.4. Шаардлагатай ажлын байранд хөдөлмөр хамгааллын хувцас өмсөж хэвших;

3.1.5. Ажилтан хооронд 1-1.5 метр зайнлас харьцах;

3.1.6. Ажлын байранд эд зүйл, багаж хэрэгслийг дамжуулж ашиглахгүй бөгөөд зайлшгүй ашиглах тохиолдолд халдвартгүйжүүлэн хэрэглэх;

3.1.7. Халдвартын сэжигтэй шинж тэмдэг /37.1 хэмээс дээш халуурах, ханиалгах, амьсгаадах/ илэрсэн үед эрүүл мэндийн болон өөрийн байгууллагад утсаар мэдэгдэж, гэртээ ажиглан тусгаарлах;

3.1.8. Хэрэглэсэн амны хаалт, бээлий зэрэг хувийн хамгаалах хэрэгслийг хог хаягдлын зориулалтын цэгт хаях;

3.1.9. Эрх бүхий байгууллагын албан тушаалтны тавьсан шаардлагыг биелүүлж, зөвлөмж, зааврыг дагаж мөрдөх.

Дөрөв. Зохион байгуулалт

4.1. Аймаг, нийслэлийн Онцгой комисс дараах үүрэгтэй:

4.1.1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 10.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэх;

4.1.2. Боловсруулах үйлдвэрийн салбарын хуулийн этгээдийн ажилчдын бүртгэл, тээврийн хэрэгслийн жагсаалт, хөдөлгөөний чиглэлийг үндэслэн зохион байгуулалтын арга хэмжээ авах;

4.1.3. Боловсруулах үйлдвэрийн салбарын хуулийн этгээдийн халдвар хамгааллын дэглэм, горимыг чанд мөрдүүлэх.

4.2. Энэ журамд заасан халдвар хамгааллын дэглэмийн мөрдөлт, халдвартгүйжүүлэлтийн арга хэмжээний хэрэгжилтэд Мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавьж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

4.3. Боловсруулах үйлдвэрийн салбарын хуулийн этгээдийн ажилтин, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд цагдаагийн байгууллага хяналт тавьж, хэв журам хамгаалж, дэмжлэг үзүүлнэ.

Тав. Бусад

5.1. Түр журмыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан тогтоол, шийдвэр, заавар, дүрэм, журам зэрэгт нийцсэн байна.

5.2. Түр журмыг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэргийг бууруулах, цуцлах хүртэлх хугацаанд дагаж мөрдөнө.

5.3. Энэхүү түр журмыг дагаж мөрдөөгүй иргэн, хуулийн этгээдийг болон хэрэгжүүлэх үүрэг бүхий этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---оОо---